



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар 129

Хужирт сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн “Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах тухай” А/193 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргийг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2024 оны 04 дүгээр сарын 15 ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд, 2024 оны төлөвлөгөөт халдваргүйтгэл, хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, “Орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн аян”-ыг 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн сумын хэмжээнд тус тус зохион байгуулсугай.
2. Аян зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн халдваргүйтгэлийн аяны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Отрын бүс нутгаас буцаж ирэх, дамжин өнгөрөх малын шилжилт хөдөлгөөний үед зөвлөн туслах, хяналт тавих, мал, амьтны сэг зэмийг устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах шатах, тослох материал, халдваргүйжүүлэлтийн хувцас хэрэгсэл, ариутгалын бодисоор хангаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Нягтлан бодогч (Г.Оюунмандах)-д даалгасугай.
4. Дээрх арга хэмжээг чанартай зохион байгуулан, удирдлага арга зүйгээр хангаж, ажлын үр дүнг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд танилцуулахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (Б.Ичинхоролцэвэлмаа), ажлын хэсгийн ахлагч (Б.Дэмбэрэл)-д нарт үүрэг болгосугай.
5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (З.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТБАЯР

622401057

D:Alban bichig;Zahiramj 2024